

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/249-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2023 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Т.Мөнхзул Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:munkhzult@audit.gov.mn">munkhzult@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-15
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16-17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17-18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18-19
5. Аудитын илрүүлэлт	20-21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	22

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗӨСТ	Зоонозын өвчин судлалын төв
ЗӨСҮТ	Зоонозын өвчин судлалын төв



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

*2023.02.25* № *СЗА-2023/249-НА-СТА-ТШЗ*

ГАНДИ \_\_\_\_\_-НЫ № \_\_\_\_\_-Г

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн 430,801.1 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 94.0 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг хэмнэснээс шалтгаалж нийт батлагдсан төсөв 6.0 хувиар хэмнэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 57.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 19.4 хувийг нормативт зардал тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/454 дүгээр тушаалаар НҮБ-ын Хүүхдийн сангаас ирсэн буцалтгүй тусламжаар 95,640.0 мянган төгрөгийн нэг удаагийн хамгаалалтын нүдний шил, аймгийн ЭМГ-аас 26,121.7 мянган төгрөгийн нэг удаагийн хамгаалах хэрэгслийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авсан ба батлагдсан төсвийн хүрээнд 22,392.7 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 71,403.3 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авч бүртгэл, тайланд тайлагнасан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.БАТМӨНХ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>22,987,454.50</b>	<b>144,606,635.50</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>22,987,454.50</b>	<b>144,606,635.50</b>
35100	<b>Түүхий эд материал</b>	<b>460,000.00</b>	<b>120,530,781.00</b>
35130	Эм боох материал	460,000.00	120,530,781.00
35400	<b>Хангамжийн материал</b>	<b>22,527,454.50</b>	<b>24,075,854.50</b>
35410	Бичиг хэргийн материал	215,750.00	269,750.00
35420	Аж ахуйн материал	19,625,004.50	22,206,104.50
35440	Түлш, шатах тослох материал	2,686,700.00	1,600,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>288,136,718.01</b>	<b>306,676,282.62</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>288,136,718.01</b>	<b>306,676,282.62</b>
39200	<b>Биет хөрөнгө</b>	<b>271,312,221.30</b>	<b>289,928,045.88</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	241,798,553.43	251,798,553.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	-24,206,402.52	-31,686,136.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл	80,735,000.00	80,735,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-54,205,000.06	-59,890,000.09
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	140,162,480.45	161,932,480.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	-117,280,470.43	-119,227,016.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,212,390.00	34,605,090.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,147,970.87	-29,498,964.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,522,825.92	1,522,825.92
39215	Хуримтлагдсан элэгдэл	-279,184.62	-363,786.02
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>16,824,496.71</b>	<b>16,748,236.74</b>
39301	Программ хангамж	1,372,400.00	1,372,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-987,903.29	-1,064,163.26
39303	Бусад биет бус хөрөнгө	16,440,000.00	16,440,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>311,124,172.51</b>	<b>451,282,918.12</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>311,124,172.51</b>	<b>451,282,918.12</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>311,124,172.51</b>	<b>451,282,918.12</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	214,786,273.00	214,786,273.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	214,786,273.00	214,786,273.00
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-119,933,838.18</b>	<b>20,224,907.43</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-111,795,643.66	-119,933,838.18
51220	Тайлант үеийн үр дүн	-8,138,194.52	140,158,745.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	216,271,737.69	216,271,737.69
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>311,124,172.51</b>	<b>451,282,918.12</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>389,703,699.00</b>	<b>569,686,026.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>23,150,400.00</b>	<b>133,531,726.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>23,150,400.00</b>	<b>133,531,726.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,931,100.00	11,770,000.00

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	19,219,300.00	121,761,726.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>366,553,299.00</b>	<b>436,154,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>332,250,900.00</b>	<b>430,801,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	332,250,900.00	430,801,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>34,302,399.00</b>	<b>5,353,200.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,823,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,600,000.00	3,530,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,702,399.00	0
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>378,518,193.52</b>	<b>380,674,720.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>378,518,193.52</b>	<b>380,674,720.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>357,678,193.52</b>	<b>354,828,600.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>217,365,199.00</b>	<b>203,462,279.62</b>
210101	Үндсэн цалин	121,885,800.26	103,883,257.72
210102	Нэмэгдэл	60,448,285.46	65,319,415.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,734,615.18	7,739,702.00
210104	Урамшуулал	25,296,498.10	26,519,904.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,132,600.00</b>	<b>28,948,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,742,100.00	19,684,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,078,100.00	2,315,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,740,600.00	1,852,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	415,600.00	463,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,156,200.00	4,631,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24,979,000.00</b>	<b>30,577,600.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,945,384.00	2,894,119.11
210302	Түлш, халаалт	19,240,076.00	24,177,885.89
210303	Цэвэр, бохир ус	2,793,540.00	3,505,595.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,449,950.00</b>	<b>20,546,900.00</b>
210401	Бичиг хэрэг	2,662,800.00	1,615,700.00
210402	Тээвэр, шатахуун	12,935,400.00	14,350,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,968,000.00	1,303,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,600.00	213,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,790,150.00	3,063,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>29,972,689.00</b>	<b>27,980,585.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,683,189.00	24,891,685.00
210502	Хоол, хүнс	0	0

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,289,500.00	3,088,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,506,400.00</b>	<b>15,525,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	30,000.00
210604	Урсгал засвар	10,506,400.00	15,495,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,000,000.00</b>	<b>9,546,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,000,000.00	9,546,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,755,500.00</b>	<b>1,764,500.00</b>
210803	Даатгалын үйлчилгээ	184,000.00	224,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,000.00	590,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	52,000.00	52,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,399,300.00	884,800.00
210807	Газрын төлбөр	13,700.00	13,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	14,500.00	0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>17,516,855.52</b>	<b>16,476,335.39</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	853,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,516,855.52	15,623,135.39
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,840,000.00</b>	<b>25,846,120.38</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>20,840,000.00</b>	<b>1,000,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,600,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,240,000.00	1,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0</b>	<b>24,846,120.38</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	24,846,120.38
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>11,185,505.48</b>	<b>189,011,305.61</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>19,323,700.00</b>	<b>48,852,560.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0	48,852,560.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	19,323,700.00	0
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-8,138,194.52</b>	<b>140,158,745.61</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>366,553,299.00</b>	<b>436,154,300.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>366,553,299.00</b>	<b>436,154,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>332,250,900.00</b>	<b>430,801,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	332,250,900.00	430,801,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>34,302,399.00</b>	<b>5,353,200.00</b>

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,823,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,600,000.00	3,530,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,702,399.00	0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>362,259,099.00</b>	<b>413,761,600.00</b>
299990	Устгал	0	0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>362,259,099.00</b>	<b>413,761,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>341,419,099.00</b>	<b>387,915,479.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>217,365,199.00</b>	<b>203,462,279.62</b>
210101	Үндсэн цалин	121,885,800.26	103,883,257.72
210102	Нэмэгдэл	60,448,285.46	65,319,415.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,734,615.18	7,739,702.00
210104	Урамшуулал	25,296,498.10	26,519,904.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,132,600.00</b>	<b>28,948,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,742,100.00	19,684,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,078,100.00	2,315,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,740,600.00	1,852,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	415,600.00	463,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,156,200.00	4,631,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24,979,000.00</b>	<b>30,577,600.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,945,384.00	2,894,119.11
210302	Түлш, халаалт	19,240,076.00	24,177,885.89
210303	Цэвэр, бохир ус	2,793,540.00	3,505,595.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,131,200.00</b>	<b>18,705,300.00</b>
210401	Бичиг хэрэг	2,793,950.00	1,669,700.00
210402	Тээвэр, шатахуун	12,222,100.00	13,264,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,968,000.00	1,303,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,600.00	213,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,053,550.00	2,254,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>31,221,200.00</b>	<b>78,532,200.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,721,200.00	71,403,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,500,000.00	7,128,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,834,400.00</b>	<b>15,525,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	328,000.00	30,000.00
210604	Урсгал засвар	10,506,400.00	15,495,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,000,000.00</b>	<b>9,546,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,000,000.00	9,546,700.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,755,500.00	1,764,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	184,000.00	224,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,000.00	590,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	52,000.00	52,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,399,300.00	884,800.00
210807	Газрын төлбөр	13,700.00	13,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	14,500.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	853,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	853,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,840,000.00	25,846,120.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,840,000.00	1,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,600,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,240,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	24,846,120.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	24,846,120.38
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,294,200.00	22,392,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,294,200.00	22,392,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,294,200.00	22,392,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,294,200.00	22,392,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,294,200.00	22,392,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,294,200.00	-22,392,700.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	430,801,100.00	405,954,979.62	24,846,120.38	94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	430,801,100.00	405,954,979.62	24,846,120.38	94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	430,577,900.00	405,954,979.62	24,622,920.38	94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	228,085,200.00	203,462,279.62	24,622,920.38	89
210101	Үндсэн цалин	130,817,800.00	103,883,257.72	26,934,542.28	79
210102	Нэмэгдэл	67,417,700.00	65,319,415.06	2,098,284.94	97

210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,702,000.00	7,739,702.00	1,962,298.00	80
210104	Урамшуулал	20,147,700.00	26,519,904.84	-6,372,204.84	132
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,948,200.00</b>	<b>28,948,200.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,684,700.00	19,684,700.00	0.00	100
210202	Тэтгэмжийн даатгал	2,315,900.00	2,315,900.00	0.00	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,852,700.00	1,852,700.00	0.00	100
210204	Ажилгүйдлийн даатгал	463,200.00	463,200.00	0.00	100
210205	Эрүүл мэндийн даатгал	4,631,700.00	4,631,700.00	0.00	100
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,577,600.00</b>	<b>30,577,600.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,939,000.00	2,894,119.11	44,880.89	98
210302	Түлш, халаалт	25,450,000.00	24,177,885.89	1,272,114.11	95
210303	Цэвэр, бохир ус	2,188,600.00	3,505,595.00	-1,316,995.00	160
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,125,300.00</b>	<b>17,125,300.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210401	Бичиг хэрэг	1,669,700.00	1,669,700.00	0.00	100
210402	Тээвэр, шатахуун	10,844,200.00	11,684,000.00	-839,800.00	108
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,876,200.00	1,303,400.00	572,800.00	69
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,062,800.00	213,600.00	849,200.00	20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,672,400.00	2,254,600.00	-582,200.00	135
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>78,532,200.00</b>	<b>78,532,200.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,403,300.00	71,403,300.00	0.00	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,128,900.00	7,128,900.00	0.00	100
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>37,918,200.00</b>	<b>37,918,200.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,422,700.00	22,422,700.00	0.00	100
210604	Урсгал засвар	15,495,500.00	15,495,500.00	0.00	100
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,626,700.00</b>	<b>7,626,700.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210702	Дотоод албан томилолт	7,626,700.00	7,626,700.00	0.00	100
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,764,500.00</b>	<b>1,764,500.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210803	Даатгалын үйлчилгээ	224,000.00	224,000.00	0.00	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	590,000.00	590,000.00	0.00	100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	52,000.00	52,000.00	0.00	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	884,800.00	884,800.00	0.00	100
210807	Газрын төлбөр	13,700.00	13,700.00	0.00	100
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>223,200.00</b>		<b>223,200.00</b>	
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>223,200.00</b>		<b>223,200.00</b>	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	223,200.00		223,200.00	

III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>430,801,100.00</b>	<b>405,954,979.62</b>	<b>24,846,120.38</b>	<b>94</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>430,801,100.00</b>	<b>405,954,979.62</b>	<b>24,846,120.38</b>	<b>94</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	430,801,100.00	405,954,979.62	24,846,120.38	94

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төгрөгөөр/
			Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>5,353,200.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>5,353,200.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>4,353,200.0</b>
2104	Хангамж бараа материалын зардал		1,580,000.0
210601	Тээвэр шатахуун		1,580,000.0
210702	Дотоод албан томилолт		1,920,000.0
210604	Бараа үйлчилгээний бусад зардал		853,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,000,000.0
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>5,353,200.0</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>5,353,200.0</b>
131105	ЗГНХ, ЗДНХөрсөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	-	<b>1,823,200.0</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	-	3,530,000.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Зоонозын өвчин судлалын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгалийн голомтод халдварт өвчин болон Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх,
- Тархалтыг судлах, уг өвчинтэй тэмцэх ажлыг зохион байгуулах,
- Мэргэжлийн тусламж үйлчилгээ, үзүүлэх.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Зоонозын өвчин судлалын төвийн санхүүгийн үйл ажиллагаанд Зоонозын үндэсний төвийн дотоод хяналт хийх баг томилогдон ирж хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ЭМЯ-ны сайдын 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/17 дугаар тушаалаар байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Уг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2017 оноос хойш холбогдох хууль, эрхийн актууд, стандартад тодорхой хэмжээний нэмэлт өөрчлөлт орсон тул эдгээр өөрчлөлтүүдэд нийцүүлэн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 140,158.7 мянган төгрөгөөр буюу 45.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Бараа материал	22,987.5	144,606.6	121,619.1
Үндсэн хөрөнгө	288,136.7	306,676.3	18,539.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>311,124.2</b>	<b>451,282.9</b>	<b>140,158.7</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>311,124.2</b>	<b>451,282.9</b>	<b>140,158.7</b>
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>311,124.2</b>	<b>451,282.9</b>	<b>140,158.7</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 144,606.6 мянган төгрөг болж өмнөх оноос 121,619.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 111,701.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 121,761.7 мянган төгрөгийн нэг удаагийн хамгаалах хэрэгсэл үнэ төлбөргүй шилжүүлэн авсан болон 111,843.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 548,406.3 мянган төгрөг болж өмнөх оноос 34,162.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 22,392.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 1,170.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер хандиваар хүлээн авсан болон аж ахуйн аргаар баригдсан

10,000.0 мянган төгрөгийн автомашины гражийг бүртгэлд нэмж тусгаснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 451,282.9 мянган төгрөг болж 140,158.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 517,732.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 187,559.8 мянган төгрөгөөр бууруулж / цалин хөлсийг 125,605.9 хангамж, бараа материалын зардлыг 6,793.7 мянган төгрөгөөр, нормативд зардлыг 22,700.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 11,164.2 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 20,633.8 мянган төгрөгөөр, гэх мэт тус тус бууруулсан нь голлон нөлөөлсөн байна./ 330,172.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт цалин, нийгмийн даатгалд төлөх зардлыг 12,366.4 мянган төгрөгөөр, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэглэлийн зардлыг 47,903.3 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах, урсгал засварын зардлыг 29,576.9 мянган төгрөгөөр гэх мэт нийт 100,628.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн зохицуулалт хийсэн байна.

Ингэснээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 430,801.1 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 430,801.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 405,955.0 мянган төгрөг буюу 94.2 хувьтай байгаа нь 2 орон тоо дутуу ажиллаж цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 24,622.9 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 223.2 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	430,577.9	405,955.0	24,622.9	94.0
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	223.2		223.2	0
	<b>Дүн</b>	<b>430,801.1</b>	<b>405,955.0</b>	<b>24,846.1</b>	<b>94.2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд ЗӨСТ-өөс орон нутагт “Халдвараас сэргийлэх хяналтыг чадавхжуулах” сургалт зохион байгуулах зардал 3,500.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2022 оны А/82 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс шагналын 1,000.0 мянган төгрөг, улсын баяр наадмаар цэнгэлдэх хүрээлэнгийн ариутгал халдваргүйжүүлэлт хийх 853.2 мянган төгрөг зэрэг нийт 5,353.2 мянган төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайлан орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн улирлын үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгохгүй байх, ажлын үр дүнг улирлаар дүгнэсний үндсэн дээр ур чадварын нэмэгдэл олгох, төсвийг бодитоор төлөвлөх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.


Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 378,518.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,785.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗӨСҮТ “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах чиглэл” цахим хурлыг зохион байгуулж харьяа газруудад чиглэл өгсний дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Тайлант онд хэвлэл захиалга хийгээгүй,
- Сургалт, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрт шилжүүлж холбогдон гарах зардлыг хэмнэсэн,

- Нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгоогүй,
- Байгууллагын цахилгааны хэрэглээнд албан хаагчдыг хэмнэлттэй байх үүрэг даалгавар өгч үр ашиггүй зардал гаргахгүй ажиллаж, өр төлбөргүй тайлагнагдсан байна.



#### **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Зоонозын өвчин судлалын төв нь мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 161 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 3, таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 3, нийт 6 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансанд мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан учир албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулах мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, холбогдох баримтад хийсэн завсрын үеийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 25,357.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,135.0 мянган төгрөгийн хортой нөхцөлийн нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт, шилэн дансны мэдээлэл дутуу мэдээлсэн 1 зөрчилд албан шаардлага, 24,222.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй, 1,238.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг шаардах хуудсаар бус жилийн эцэст бөөн дүнгээр зарлагадсан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн нь 83.3 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,135.0	1	1,1135.0	100.0
Албан шаардлага	1	-	1		100.0
Зөвлөмж	2	24,222.2	1	21,771.2	50.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>25,357.2</b>	<b>3</b>	<b>22,906.2</b>	<b>83.3</b>

Өмнөх онд өгөгдсөн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ковид 19 цар тахлын өвчний цар хүрээ намжмал байдалд орсон атал нэг удаагийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх гэх үндэслэлээр шаардлагагүй нэг удаагийн хэрэгслийг шат шатны төсвийн захирагчдаас давхардуулан бэлтгэж, ашиглалтгүй бараа материал бэлтгэж, 120,530.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа учраас дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна.

1. Ковид өвчин ихсэж болзошгүй гэх шалтгаанаар тайлант онд тус төвийн төсвийг нэмэгдүүлэн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэглэлийн зардлыг 50,590.0 мянган төгрөгөөр санхүүжүүлж био аюулгүйн сав /зүү мултлагчтай хуванцар/ 2500 ширхэг, бээлий 500 ширхэг, нэг удаагийн халат 1000 ширхэг, N95 маск 9000 ширхэг, нүүрний хаалт 1200 ширхэг, нүдний шил 1200 ширхэг зэрэг нийт 6 нэр төрлийн нэг удаагийн хамгаалалтын хэрэгсэл худалдан авснаас 46,206,5 мянган төгрөгийн нэг удаагийн хэрэглэлийг нь зарцуулагдаагүй бөгөөд бараа материалын үлдэгдлээр тайлагнагдсан байна.

2. Батлагдсан төсвийн хүрээнд дээрх 50,590.0 мянган төгрөгийн нэг удаагийн хамгаалах хэрэгсэл худалдан авч нөөцөлсөн байхад аймгийн ЭМГ-аас төсвийн жил дуусахын өмнө буюу 11 дүгээр сард дахин аюулгүйн хайрцаг 50 ширхэг, нэг удаагийн комбинезон 394 ширхэг, амны хаалт 2500 ширхэг, бээлий 2600 ширхэг, нэг удаагийн халат 120 ширхэг, N95 маск 500 ширхэг, нүүрний хаалт 300 ширхэг, нүдний шил 140 ширхэг, малгай 300ш, улавч 500ш, хормогч 70ш гэх мэт 10 төрлийн 26,121.7 мянган төгрөгийн нэг удаагийн хамгаалалтын хэрэгсэл зэргийг шилжүүлэн өгсөн нь мөн материалын үлдэгдлээр тайлагнагдсан байна.
3. НҮБ-ын Хүүхдийн сангаас буцалтгүй тусламжийн хүрээнд олгосон 95,640,0 мянган төгрөгийн үнэ бүхий 10,000 ширхэг нэг удаагийн хамгаалалтын нүдний шилийг ЭМЯ-наас хуваарилагдан ирснээс 4960 ширхгийг сумдын эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлж оны эцэст 5040 ширхэг буюу нийт 48,202.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "*нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх*" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа илрээгүй.

Аудитаар нийт 12,119.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,630.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 8,489.7 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөв.

### 5.1 Албан шаардлага:

1. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 3,630.0 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 5.2.1. Төрийн албан хаагчийн урамшуулал давхардуулан олгосонтой холбоотой асуудал:

1. Илрүүлэлт: Нягтлан бодогч М.Сэлэнгийн ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгосон боловч ЭМС-ын 2022 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн А/380 дугаар тушаалаар 2021 оны ажлыг “Хангалттай” үнэлүүлсэн гэх үндэслэлээр 2 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,664.7 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг үр дүн, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, нэг ажлын үр дүнгээр урамшууллыг давхардуулан олгохгүй байх

#### **5.2.2. Ур чадварын нэмэгдэл олгохтой холбоотой асуудал**

Илрүүлэлт: Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдэлд 6,825.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3-д "Төрийн үйлчилгээний байгууллагын... албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу ... тооцож, сар бүр олгоно" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу улирлаар дүгнэсний үндсэн дээр ур чадварын нэмэгдлийг сар бүр олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй	1	3,630.0			1	3,630.0						
Төрийн албан хаагчийн урамшуулал давхардуулан олгосон	1	1,664.7					1	1,664.7				
Ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнээгүй олгосон	1	6,825.0					1	6,825.0				
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>12,119.7</b>			<b>1</b>	<b>3,630.0</b>	<b>2</b>	<b>8,489.7</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	6						6					
<b>Дүн</b>	<b>6</b>						<b>6</b>					
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
<b>Дүн</b>												
<b>Нийт дүн</b>	<b>6</b>						<b>6</b>					



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 18/А1870463

Сүхбаатар

СНА-2023/219-НАСМЖЛЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ. Үүнд:

- Төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 3,030.0 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн,
- Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 6 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Эдгээр нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...", Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-6.4.8 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар

018740753

тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана, 4.2.1.10: Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол, 4.2.1.11: "Хууль тогтоомж, ... зөрчсөн ..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх зөрчлүүдийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын төвийн дарга Н.Эрдэнэбат, нягтлан бодогч М.Сэлэнгэ нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Б.БАТМӨНХ

АУДИТОР:



Т.МӨНХЗУЛ

